БАТЛАВ
ЦОГ-ОРНӨХ ОНӨААТҮГАЗРЫН
ЗАХИРАЛ .....Ц.АРДТҮМЭН

Техникийн нөхцөл олгох комиссын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тоот хурлаар хэлэлцэж зөвшөөрөв.

ТЕХНИКИЙН ДААЛГАВАР № 01/2025

1. **Хэрэглэгчийн нэр: Өмнөговь, Цогтцэций сумын Ерөнхий боловсролын нэг дүгээр сургууль**
2. **Барилгын мэдээлэл: 640 хүүхдийн сургуулийн барилга** 88539797
3. **Хэрэглэгчийн байршил: Өмнөговь аймаг, Цогтцэций сумын төв, 3-р баг**
4. **Дулааны хэрэглээ:**

Д/д	Дулааны эрчим хүчний ачаалал /томсгосон тооцоо/	Тоо хэмжээ	Тодорхойлох нэгж
1	Халаалт	0.4	Гкал/ цаг
2	Хэрэгцээний халуун ус	0.089	Гкал/ цаг
3	Салхилуулга	0.03	Гкал/ цаг
	Нийт ачаалал	0.52	Гкал/ цаг
4	Барилгын талбай	-	м2
5	Барилгын эзэлхүүн	28787	м3

4.1Холболтын цэг:

- Төв шугамын ДХ-5 дугаар худгийн 100 мм диаметртэй дулааны шугамаас оготолгоо авах таслах хаалт, хий авагч, юүлэгчийн хамт төлөвлөх,
- Барилгын гадна хяналтын болон эргэлтийн худаг төлөвлөх балансын хаалттай

Шугамын даралт, температурын утга:

А. Холболтын цэг дээр байх түрэлт
Б. Буцах шугамын даралт 4.0 кгс/см2
В. Гадна агаарын тооцоот температур -26,2 ° С
Г. Температурын график 90/70 ° С

5. **Мөрдөх, хэрэгжүүлэх хууль, дүрэм, журам:**
   5.1 Эрчим хүчний тухай хууль
   5.2 Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 тоот тогтоолоор батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"
   5.2 Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 290 дүгээр тогтоолоор батлагдсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний "Холболтийн журам"
   5.3 Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 19 дүгээр тушаалаар батлагдсан БНбД 41-05-18 "Дулааны сүлжээ" бусад БНбД

6 Зураг төсөл, төсөв боловсруулахад тавигдах шаардлага:

6.1 Эрчим хүчний тухай хууль, Барилгын тухай хууль эдгээрт холбогдох дүрэм журам, БНбД, стандартын дагуу зураг төсөл болон төсвийг зохиох.

6.2 Төлөвлөж буй барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн зураг төсөл, төсвийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийж гүйцэтгүүлэнэ.

6.3 " Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 1.3 дах заалтыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаас хамгаалалтын зурвасын зайг хангаж барилгыг төлөвлөх.

6.4 Шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ салаа шугам эзэмшигч, шугамын трасс дагуух газар эзэмшигчтэй урьдчилан зөвшөөрөлцөх, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.

6.5 Төлөвлөж буй барилга байгууламж, гадна дулааны шугам, тоног төхөөрөмжийн угсралтын ажлын зургийг техникийн нөхцөл олгогчтой зөвшилцөн хянуулаж магадлал хийлгэж баталгаажуулах.

6.6 Төлөвлөж буй барилга байгууламжид төвлөрсөн дулаан хангамжийн техник ашиглалтын шаардлага хангасан халаалтын цогц төхөөрөмж, зангилааг төлөвлөх.

6.7 Гадна дулааны шугам болон дулааны зангилааг БНбД 41-04-13 "Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт" нормд нийцсэн материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах.

6.8 Гадна дулааны шугам сүлжээ авто зам бусад инженерийн шугам сүлжээтэй огтлолцох хэсэгт нэвтрэх болон хагас нэвтрэлттэй сувагтай, хүчитгэсэн гэртэй байхаар зураг төсөвт тусгах.

6.9 Төлөвлөж буй шугам сүлжээ нь газар доорхи бусад инженерийн шугам сүлжээтэй огтлолцох үед бүрэн бүтэн байдлыг хангах, зам талбай, ногоон байгууламжийг нөхөн сэргээх зардал болон гадна дулааны шугам, узель дотор системийн угаалт, шахалтын туршилт, горим тохируулага хийх зардлыг төсөвт тусгаж хэрэгжүүлэх.

7 Обьект, барилга байгууламжийг шугам сүлжээнд холбох:

7.1 Обьект, барилга байгууламжийн гадна болон дотор системийн угаалт, шахалтын туршилт хийн акт бүрдүүлж горимын тохируулга, дулааны шугам сүлжээнд холбох бэлтгэл ажил хийж бэлэн болсон тухай "ЦОГ-ӨРНӨХ" ОНӨААТҮГ-т албан ёсоор мэдэгдэн хяналт хийлгэн зөвшөөрлийн дагуу ДЭХ-ээр хангагдана.

7.2 Барилгын ажил гүйцэтгэгч эсвэл иргэн, ААН нь угсралтын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэх ба гүйцэтгэлийн явцад орон нутгийн болон "ЦОГ-ӨРНӨХ" ОНӨААТҮГ-ын ИТА-ны хяналт, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

7.3 Иргэн, ААН нь гадна дулааны шугам сүлжээний эзэмшилийн заагийг тогтоож, барилга байгууламжийн гүйцэтгэгч болон ашиглагч байгууллагууд хүлээлцсэн актыг үндэслэн "ЦОГ-ӨРНӨХ" ОНӨААТҮГ-тай ДЭХ худалдах, худалдан авах гэрээ байгуулна.

7.4 Шугам сүлжээний угсралтын ажлыг ЭХЯ-аас олгогддог тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгэх үүрэгтэй. Мэргэжлийн бус бригад болон хувь хүнээр хийлгэхийг хатуу хориглоно.

7.5 Гадна дулааны шугамын худаг, сувагжилтыг цутгамал төмөр бетон болон угсармал бетон эдлэлээр хийж гүйцэтгэх ба гулсах, үл хөдлөх тулгууруудыг норм стандарт зураг төсөвт заагдсаны дагуу хийж гүйцэтгэнэ. Өрөгт хийцээр дулааны шугамын худаг сувагжилтыг хийж гүйцэтгэхийг хориглоно.

7.6 Гадна дулааны шугам сүлжээг хийж гүйцэтгэх үед бусад инженерийн шугам сүлжээний бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангана.

7.7 Дотор халаалтын системд техник ашиглалтын шаадлага хангасан халаах хэрэгсэлийг тохируулах, таслах хаалтын хамт төлөвлөх, гол болон жигүүрүүдэд хаалт юүлэгч, босоо шугамуудад тохируулах хаалт болон агаар гаргагч хий хураагчийг норм стандартад нийцүүлэн төлөвлөж гүйцэтгэнэ.

7.8 Барилгын дулааны зангилаанд таслах хаалт, хог шүүгч, температур тохируулах хаалт, хэмжих шалгах хэрэгсэлүүдийг норм дүрмийн дагуу суурьлуулж нэр хаягийг байршуулах.

7.9 Тусгай заалтууд:

7.10 Холих насосны үзельтэй байна.

7.11 -Ялтсан дулаан солилцуурыг өөрийн барилгын талбайн хэмжээнд тохируулан сонгож холбох.

7.12 -Дулааны шугамыг сувагжилттай, бетонон хучилттай, дулаалгатай хийх.

7.13 - Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх шаардлагатай.

7.14 Иргэн хуулийн этгээд нь газар доорх инженерийн шугам сүлжээг дайран гарах болон зам талбай, ногоон байгууламжийг нөхөн сэргээхэд гарах зардлыг хариуцаж нөхөн сэргээж засварлана.

8 Техникийн нөхцөлд тавигдах нэмэлт шаардлага:

8.1 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 30 дугаар зүйлийн 30.1.10 дах заалтыг мөрдөж өөрийн эзэмшилийн шугам, тоног төхөөрөмжөөс шинээр хэрэглэгчийг холбох ДЭХ хангах үүрэг хүлээнэ.

8.2 Дулааны шугам, барилга байгууламжийн дотор систем, тоног төхөөрөмж угсрах, шугам хоолойн дулаалга хийхдээ техник ашиглалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөж ажиллах.

8.3 Төлөвлөж буй барилгын дулааны ачааллыг техникийн нөхцөлийн олгох жураманд заагдсан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, өргөтгөлийн барилга нэмж төлөвлөхгүй байх.

8.4 Техникийн нөхцөлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй.

8.5 Олгосон техникийн нөхцлийн шаардлагуудыг захиалагч байгууллага нь зураг төсөв зохиогч болон гүйцэтгэгч байгууллагад албан ёсоор танилцуулж, шаардлагатай бол хувилж өгөх үүрэгтэй.

8.6 Иргэн, ААН нь өөрийн эзэмшилийн шугам, тоног төхөөрөмжид хэрэглэгч шинээр холбуулахдаа түгээх сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаатай хобоотой хангагчаас тавих шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

8.7 Олгосон техникийн нөхцлийг " ЦОГ-ӨРНӨХ" ОНӨААТҮГ-ын зөвшөөрөлгүй өөрчлөхийг хориглоно.

9 Архивт бүрдүүлэх материал:

9.1 Обьект, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, дулаан дамжуулах төвийн гүйцэтгэлийн баримт бичиг, туршилтын акт, гүйцэтгэлийн зураг, байнгын ашиглалтанд оруулах комиссын дүгнэлт.

9.2 Иргэн, хуулийн этгээд хувийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын гүйцэтгэлийн үеийн бүрдүүлэх баримт бичиг. Үүнд:

- "ЦОГ-ӨРНӨХ" ОНӨААТҮГ-ийн төлөөлөгчийг байлцуулан угаалт, туршилт, тохируулга хийсэн ил далд ажлын акт, фото зураг
- Шугам сүлжээ, тоног төхөөрөмж, хаалт арматурын сертификат, паспорт, ашиглалтын заавар
- Гүйцэтгэлийн зураг, угсралтын тойм зураг, схем
- Хийж гүйцэтгэсэн байгууллагын болон ажилчидын тусгай зөвшөөрөл, үнэмлэхний хуулбар

9.3 Шинээр суурьлуулсан дулааны тоолуурын угсралтын акт түүний баримт бичиг, тоолуур суурьлуулсан ААН-ийн тусгай зөвшөөрлийн хуулбар.

10 Техникийн нөхцөл олгох үндэслэл

10.1 Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 100 дугаар захирамж, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ерөнхий боловсролын нэг дүгээр сургуулийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 75 тоот албан бичиг, Эрхэс констракшн ХХК-ны 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 79/2025 тоот албан бичиг

11 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

11.1 Энэхүү техникийн нөхцөл олгосон өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна

12 Техникийн нөхцөл хүчингүй болох

12.1 Хугацаа дуусан бол хүчингүйд тооцно.

12.2 Энэхүү техникий нөхцөлийн аль нэг заалтыг биелүүлээгүй бол хүчингүй.

12.3 Техникийн нөхцөлийн ачаалал 20-иос дээш хувиар өөрчлөгдсөн бол дахин авна.

12.4 Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд тухайн обьект ашиглалтанд орж дулааны сүлжээнд холбогдоогүй бол хүчингүйд тооцно.

12.5 Хугацаа дуусан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.

12.6 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтийг гаргах бөгөөд техникийн нөхцөлийг 1 удаа сунгана.

13 Хариуцлага

13.1 Техникийн нөхцөл олгогч, иргэн, ААН нь техникийн нөхцөлтэй холбоотой гарсан маргааныг Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 209-р тогтоолоор батласан "Дулаан дамжуулах, түгээх сүлжээний холболтын журам" болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

МЕХАНИК	С.ХАТАНБААТАР
ДУЛААНЫ АХЛАХ	Ө.БЯМБА-АДЪЯА
УС ХАНГАМЖИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН	Б.БУЛГАНТАМИР
БОРЛУУЛАЛТЫН АЖИЛТАН	Л.БҮРЭНБАЯР

БАТЛАВ

Цог-Өрнөх ОНӨААТҮГ-ын захирал

.....Ц.АРДТҮМЭН

ӨМНӨГОВЬ АЙМАГ Цог-Өрнөх ОНӨААТҮГ 1125020052 ХТУ9096 2015625

УС ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 01/2025

Техникийн нөхцөл олгох
комиссын 2025 оны 04 сарын
15-ны өдрийн хурлын 01
тоот протоколыг үндэслэн зөвшөөрөв.

1	Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил	Цогтцэций сум төв, 3-р баг. 640 хүүхдийн сургуулийн барилга
2	Нийт усны хэрэглээ	• Цэвэр усны ахуйн хэрэгцээнд 13 м3/хоногт • Галын усны 5 л/сек • Бохир усны 13 м3/хоногт
3	Цэвэр усны холболт хийх цэгийн байршил,шугмын диаметр, даралт	• төвийн шугамын ЦХ-16 дугаар худгийн 159 мм-ын диаметртэй цэвэр усны шугамаас огтолгоо авах таслах хаалт, юүлэгчийн хамт хийх, • Барилгын гадна хяналтын худаг төлөвлөх • Шугам сүлжээнд огтолгоо хийхдээ 24 цагийн өмнө Цог-Өрнөх ОНӨААТҮГазарт албан тоот болон биечлэн мэдэгдэх. • Шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах шугам сүлжээ, зам, талбай, бут, сөөгийг сэргээн засварлах. • Далд ажлыг / газар доорх ажлыг Цог-Өрнөх ОНӨААТҮГ-ын Инженер техникийн ажилтнуудад мэдэгдэж фото зураг авхуулах/ баримтжуулах.
4	Бохир усны холболт хийх цэгийн байршил,шугмын диаметр	• Төв шугамын БХ-32 дугаар худгийн 159 мм диаметртэй шугамаас огтолгоо авах • Барилгын гадна талд стандартын шаардлага хангасан анхан шатны худаг үүсгэх
5	Нэмэлт нөхцөл	• Ус хангамж- туршилт тохируулгын ажлын зардлыг төсөвт тусгах. • Ариутгах татуурга-туршилт тохируулгын ажлын зардлыг төсөвт тусгах. • Цэвэр усны нэгдсэн тоолуур, даралт өсгөх вакум насосыг барилгын үзельд байруулах. • Ажлын зураг, төсвийн нэг хувийг хавсрагдах баримт бичгүүдийн хамт

		Цог-Өрнөх ОНӨААТҮГ-ын архивт өгөх.
6	Тавигдах шаардлага	1.Барилгыг хот,суурины ус хангамж,ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дагуу цэвэр усны шугмын тэнхлэгээс 5 м, бохир усны шугмын тэнхлэгээс 6 м зайд барих. 2. Хот,суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 15.1.10 дагуу хангагч нь хэрэглэгчийн шугмаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгож,батлагдсан ажлын зураг төслийн дагуу дараагийн хэрэглэгчийг холбуулах. 3. Цэвэр,бохир усны шугмын угсралт,шахалт туршилтын үед ашиглалтын байгууллагын хяналтын инженерийг байлцуулж ил далд ажлын акт үйлдэнэ. 4. Ус хангамж,ариутгах татуургын холболтын зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх. 5. Хэрэглэгчдэд баталгаажуулсан усны тоолуур тавих. 6.Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 11.1.3-т зааснаар хангагч нь хэрэглэгчийн шугамнаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгосон тохиолдолд татгалзахгүй холбуулах. 8.Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 11.4-д зааснаар Техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагыг зөрчихийг хориглоно. 9.Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа 2 жил.
7	Обьект барих дээд газрын шийдвэр	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 100 дугаар захирамж, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ерөнхий боловсролын нэг дүгээр сургуулийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 75 тоот албан бичиг, Эрхэс констракшн ХХК-ны 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 79/2025 тоот албан бичиг
8	Хэрэглэгчийн нэр,утас	Ерөнхий боловсролын нэг дүгээр сургууль утас: 88539797

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

МЕХАНИК	С.ХАТАНБААТАР
ДУЛААНЫ АХЛАХ	Ө.БЯМБА-АДЪЯА
УС ХАНГАМЖИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН	Б.БУЛГАНТАМИР
БОРЛУУЛАЛТЫН АЖИЛТАН	Л.БҮРЭНБАЯР

БАТЛАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ЖАРГАЛСАЙХАН

"ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК

ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНД ХОЛБОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №86/2025

2025 оны 04 дугаар сар 30

1. Хэрэглэгчийн нэр, хаяг: " Өмнөговь аймаг Цогтцэций сум ерөнхий боловсролын 1-р сургууль" Өмнөговь аймаг Цогтцэций сум Цагаан овоо баг
2. Техникийн нөхцөл авах объектийн нэр, байршил: 640 хүүхдийн сургуулийн цахилгаан хангамжийн зураг төсөв, Өмнөговь аймаг Цогтцэций сум
3. Хэрэгцээт хүчин чадал: (урьдчилсан тооцоогоор) **500кВт**
4. Хэрэглэгчийн ажлын горим: 24 цаг
5. Хэрэглэгчийн зэрэг: Гурав
6. Холбогдох цэг: 10 кВ-ын сум баруун гаргалгааны ТП-3 дэд өртөөний 10 кВ-ын тулгуураас

Ерөнхий шаардлага:

7.1 Хэрэглэгч нь мэргэжлийн эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээр зураг төслийг хийлгэнэ. Зураг төсөл зохиогч нь техникийн нөхцлийн дагуу зураг төслийг боловсруулж, "ӨБЦТС"ТӨХК-иар хянуулан зөвшилцөл хийж, зургийн 1 хувийг техникийн нөхцөл олгогчид өгнө.

7.2 Зураг төсөлгүй буюу зөвшилцөл хийгээгүй зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

7.3 Хэрэглэгчийн цахилгааны шугам сүлжээг барихад газар доорхи инженерийн сүлжээг дайрч гарах зам талбай, мод бут сөөг эвдэх, тайрах тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусган хэрэгжүүлнэ. Хэрэглэгч нь шугам сүлжээг угсрах явцад бусад инженерийн сүлжээтэй тааралдаж байгаа бол түүнийг хамгаалах, бүрэн бүтэн байдлыг нь хариуцах үүрэгтэй.

7.4 Хэрэглэгч нь цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу "ӨБЦТС" ТӨХК-ийн техникийн ажилтны хяналт, зөвлөмжийн дор гүйцэтгэнэ.

7.5 Хэрэглэгч нь цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг хийж дууссаны дараа техникийн нөхцөл олгогчийн төлөөлөгчийг байлцуулан туршилт тохируулгын ажлыг хийж холбогдох акт баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Гүйцэтгэлийн зураг
- Ажлын зураг, түүнд зураг төслийн байгууллагатай зөвшөөрөлцөж оруулсан өөрчлөлтүүд.
- Суурилагдсан тооцооны болон хяналтын хэмжүүрүүдийн паспорт, улсын баталгаажуулалтын гэрчилгээ.
- Туршилт тохируулгын баталгаажсан лабораторын акт бичиг баримт, ашиглалтын заавар.
- Кабелийн трассын координатын байршил, трассын зураг.

8. Зураг төсөл зохиох, угсралтын ажил гүйцэтгэхэд биелүүлэх шаардлага:

- 35/10 кВ-ын Цогтцэций дэд станц, 10 кВ-ын сум баруун гаргалгааны реле хамгаалалтын тавил тооцоог хийлгэж хангагч байгуулагаар тавиулах.
- 35/10 кВ-ын Цогтцэций дэд станцын 10 кВ-ын сум баруун гаргалгааны горимын тооцоо хийлгэж хангагч байгуулагад хүлээлгэж өгөх.
- 10 кВ-ын сум баруун гаргалгааны ТП-3 дэд өртөөний 10 кВ-ын ЦДАШ-н тулгуурт хуурай салгуур монтажлан 10 кВ-ын хос 3*120 мм голчтой XLPE хамгаалалтай кабель шугам татах.
- ТП-3 дэд өртөөний авлага авч байгаа салбарын тулгуурт 10 кВ-ын гүйдлийн трансформатор, микропроцессийн релетэй, гүйдлийн хамгаалалт оруулах, алсаас тасалж залгах боломжтой ӨБЦТС ТӨХК-ийн диспетчерийн хяналтын скада системд холбогдох боломжтой 10 кВ-ын ухаалаг реклоузер таслуур монтажлан хангагч байгуулагаар реле хамгаалалтын тавилыг бодуулж тавиулах.
- Шинээр татсан 10 кВ-ын ЦДКШ-ын төгсгөлд S-11 маркын 630 кВа трансформатортай 10 кВ-ын кабель оруулагатай КТПН дэд өртөө монтажлах ба уг дэд өртөө нь 0.4 кВ-ын иж бүрэн автомат щит хайрцагтай дэд өртөө монтажлах. Дэд өртөөний газардуулах байгууламжийг шинээр хийх.
- Дэд өртөөний гадуур хамгаалалтын торон хашаатай байна.
- Дэд өртөөнд 10кВ-ын гал хамгаалагч, Орос улсад үйлдвэрлэсэн РВО маркийн 10 кВ-ын цэнэг шавхагч суурилуулах.
- Дэд өртөөнүүдийн 0.4 кВ-ын щит хайрцаг нь IP-54 стандарт шаардлага нийцсэн байх ба гаргалгааны таслах залгах хэрэгсэлийг ачаалалаас хамааруулж сонгох.
- Шинээр баригдсан дэд өртөөний 0.4 кВ-ын щит хайрцагнаас хос кабель шугамаар сувагжилт хийж тэжээл татах ба кабель шугамын хөндлөн огтлолыг ачааллаас хамааруулж сонгож тооцох.
- Шинээр угсарсан дэд өртөөний толгой дээр 800/5 гүйдлийн трансформатор, **3 фазын 5А /DTSD545S/,** тоолуур угсарч тоноглох. Дэд станцад байрлах тоолуур нь "ӨБЦТС" ТӨХК-ийн ухаалаг тоолуурын системд бүрэн нийцэж ажилладаг тоолуур суурилуулах ба олон улсын DLMS протокол дэмждэг, тухайн 0.4 кВ-ын дэд станцын мэдээлэл цуглуулах дата концентратортой PLC буюу хүчдэлийн шугамаар холбогдож мэдээллээ илгээдэг байх. Мөн GSM сүлжээгээр мэдээлэл дамжуулах сим картны оролттой байх. RS485, оптик холболтоор холбогдон тохиргоо, үзлэг үйлчилгээ хийх боломжтой байх.
- Шинээр угсарсан дэд өртөөнд **<u>Мэдээлэл цуглуулж, дамжуулах дата концентратор</u>**: Хэрэглэгчдийн ухаалаг тоолуураас шаардлагатай параметрүүдийг ямар нэгэн нэмэлт холболтын кабель шаардахгүй, PLC /power line carrier/ буюу хүчдэлийн шугамаар дамжуулан авч байдаг төхөөрөмж бөгөөд 0.4 кВ-ын хүчдэлийн түвшинтэй дэд станцын толгой тоолуурын хамт байрлана. Дата концентратор нь үүрэн холбооны GSM сүлжээний 3G/4G хурдаар мэдээллийг "Ухаалаг тоолуурын төв сервер"-т илгээх ба нэмэлт антеннатай байна.
- Шинээр угсарсан дэд өртөө, 0,4 кВ-ын щит хайрцагт хангагч байгуулагаас олгосон дэд станцын нэр болон дугаарыг төмөр хийцээр ААД, ТАД-н дагуу хийж гүйцэтгэх.
- Тооцооны гүйдлийн трансформатор, хэмжүүрийн гүйдлийн трансформаторыг тус хэмжил зүйн загварын туршилтаар баталгаажсан байх ба хэмжил зүйн баталгаанд орсон байх.
- Шинээр татсан шугам сүлжээ тоноглолыг хүчдэлд залгах, туршилт тохируулагын ажлыг **<u>хангагч байгуулагаар</u>** хийлгэх.
- Шинээр угсарах КТПН-д байгалын гэрэлтүүлэг тусдаг болон эрчим хүчний хэмнэлтэй гэрэлтүүлэг тоноглож өгөх. Мөн ячёйк тус бүрийн ард тэсэрдэг галын хор байршуулж өгөх.
- Ухаалаг тоолуурын GSM сүлжээний мэдээлэл дамжуулах сим картыг "ӨБЦТС" ТӨХК-аас авах ба ухаалаг тоолуурт тохиргоо үйлчилгээ хийгдсэн байна.

- Ухаалаг тоолуурын GSM сүлжээний сим картны сунгалтын төлбөрийг сар бүр цахилгаан эрчим хүчний төлбөр дээр нэмж тооцохыг анхаарна уу.
- Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ "ӨБЦТС" ТӨХК-н хяналтан дор мэргэжлийн байгууллагаар хийлгэж хамтарч ажиллах.
- Хэмжих хэрэгсэл буюу цахилгаан эрчим хүчний тоолуурыг Хэмжил зүйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7-д заасан /хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх бол чадавхаа үнэлүүлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлэх/-сэн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх.
- "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй" гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.
- Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30,1,10 дахь заалтын дагуу цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагын техникийн нөхцөл олгосон хэрэглэгчдийг өөрийн эзэмшилийн шугам, дэд станцаас аливаа нэмэлт зардалгүйгээр цахилгаан эрчим хүчээр хангах үүрэгтэй.
- Угсралтын ажлыг эхлэх үе шат бүрт хангагч байгууллагатай зөвшилцөж байх.
- Шугам, дэд станц барих угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм болон Техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
- Хэрэглэгчийн цахилгааны шугам сүлжээг барихад зам талбай, мод бут сөөг эвдэх, тайрах тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусган хэрэгжүүлэх.

9. Техникийн нөхцөл нь олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

10. Техникийн нөхцөлийг явуулсан газрууд:

"Цогтцэций сум ерөнхий боловсролын 1-р сурнууль" захирал М.Ганзориг
Утас 88539797

11.Техникийн нөхцөлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР	Т.ГАНТӨМӨР
ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА	М.БАНЗРАГЧ
ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВИЙН ДАРГА	Ц.НАРАНТУЯА
РЕЛЕ ХАМГААЛАЛТ, ТОХИРУУЛАГЫН ИНЖЕНЕР	Б.ТҮМЭНБАЯР
ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТ СУДАЛГААНЫ МЕНЕЖЕР	М.ГАНЗОРИГ

Техникийн нөхцөл хүлээлгэн өгсөн
Борлуулалт, техникийн инженер

2025 оны 04 сарын ....өдөр

Техникийн нөхцөл хүлээн авсан
"1-р сургуулийн" -ийн төлөөлөгч

2025 оны 04 сарын ....өдөр

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 24-ны өдрийн
А/92 тоот тушаалын Хоёрдугаар хавсралт Маягт-15

MONGOLIA NETCOM
ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

БАТЛАВ:
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ДАРГА.....Н.БАЯРАА

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар D-A2025/42

/Өмнөговь аймаг/ 2025 оны 04 сарын 24 өдөр

Захиалагч: Өмнөговь аймаг ЗДТГазар

Харилцах утас: 88539797

Байршил: Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт

Зориулалт: 640 Хүүхдийн сургууль

Холбооны хэрэгцээ: Холбооны стандарт бүхий худаг,сувагчлал хийх

Шилэн кабель 12 кор

1. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга обьектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

2. **Техникийн үндсэн нөхцөл:**
Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт шинээр баригдахаар төлөвлөж буй 640 хүүхдийн сургуулийн барилгыг холбоожуулахад дараах техникийн нөхцөлийг олгож байна.Үүнд:
   2.1 Цогтцэций сумын ХХ2-р худгаас цааш чанар стандартын шаардлага хангахуйц 100мм-ийн диаметртэй PVC хоолойгоор 2+0 эгнээтэй сувагчлалыг төлөвлөж буй шинэ сургуулийн техникийн өрөө хүртэл 100 метр тутамд болон булан тохой хэсэгт шинээр холбооны стандарт бүхий худгийг /ТБУХ-1/ суурилуулна.
   2.2 12 корын шилэн кабелийг МХС ХХК-ийн салбарын байрны техникийн өрөөнөөс ХХ1,9-р худагт муфтлэж шинээр хийсэн худаг сувагчлал болон уг барилгын техникийн өрөө хүртэл дамжуулан татаж барилгын дотор серверийн өрөөнд төгсгөлийн төхөөрөмж FDF-д холбоно.FDF-ийг зориулалтын дагуу суурилуулна.
   2.3 Дохиолол, домофон систем, телефон холбоо, кабелийн телевиз, интернэт, хяналтын систем, шинэ үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийг байршуулах техникийн өрөөг зайлшгүй төлөвлөх шаардлагатай.
3. **Зураг төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцөлүүд:**
   3.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2013, MNS 5279:2013, MNS 5280:2003, MNS 6668:2017, MNS 6581:2016, MNS 3966:2017, MNS 6305:2012, MNS 4908:2017, MNS 5532:2005 ерөнхий шаардлагууд болон 2019 онд шинэчлэн баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5-р зүйлд заасны дагуу гүйцэтгэх.
   3.2 Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж зураг төсөвт оруулах.
   3.3 Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.
   3.4 Дээрх техникийн нөхцөлийн дагуу ажлын зураг гүйцэтгэхдээ тухайн ашиглалт хариуцсан газар нэгжээр техникийн шийдлийг хянуулан, зөвшилцөж батлуулна. (Утас: 70532110)

3.5 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.

3.6 Шинээр хийх сувагчлалын трасс хийх ажлын зургийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын болон инженерийн шугам сүлжээтэй газруудын холбогдох албан тушаалтнаар шалгуулан баталгаажуулсан байх.

4. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**

4.1 Техникийн нөхцөл, ажлын зураг төсвийн дагуу угсралтын ажил эхлэхээс өмнө Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ашиглалт хариуцсан газар, нэгжээс ажил эхлэх зөвшөөрлийг авч тухайн ашиглалт хариуцсан газар, нэгжийн хяналтан дор гүйцэтгэнэ.

4.2 Газар шорооны ажил эхлэхийн өмнө ГХБХБГ-ын мэргэжилтнээр трассын зургийг хянуулан зөвшөөрөл авсан байх.

4.3 Газар шорооны ажил гүйцэтгэхдээ тухайн харъяалагдах газар нэгжээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актад хавсаргах.

4.4 Шинээр татсан кабель болон FDF-д тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.

4.5 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулж ажиллах.

4.6 Хэрэглэгч холбох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол Улсын стандарт MNS 6581:2016 ерөнхий шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

4.7 Шинээр хийгдсэн худаг сувагчлалын байгууламжийг "Шугам сүлжээний гүйцэтгэлийн зураглалыг шалгаж барилга хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авсан акт", CD-ний хамт ашиглалтын байгууллагад хүлээлгэж өгсний үндсэн дээр худаг сувагчлалын гүйцэтгэлийн зургийг гаргуулна.

5. **Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:**

5.1 Шинээр суурилуулсан худаг сувагчлалын байгууламжийг гүйцэтгэлийн актаар хүлээлгэн өгснөөр ашиглалтын явцад гарах засвар үйлчилгээг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь хариуцна.

5.2 Уг худаг сувагчлалын байгууламж нь цааш үргэлжлүүлэн төлөвлөх, засвар үйлчилгээ хийх, мөн харилцаа холбооны бусад үйлчилгээний зориулалтаар шилэн кабель шинээр суурилуулах зэрэг нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх.

6. **Техникийн нөхцөлийг: Цогтцэций сумын ерөнхий боловсролын нэг дүгээр сургуулийн 2025 оны 04 сарын 08-ны өдрийн 77 тоот албан хүсэлтийг үндэслэн олгов.**

7. **Угсралтын ажил дууссаны дараа Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний хариуцсан нэгжээр хэмжилт шалгалт хийлгэж, техникийн актаар хүлээлгэн өгснөөр сүлжээнд холбогдох боломжтой.**

8. **Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцөлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалтыг олгоно.**

Хянасан: А.НАРАНТУНГАЛАГ/ Ерөнхий инженер /

Боловсруулсан: Э.УЧРАЛТБЯМБА / Кабель шугамын инженер /